



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/64/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Эм Аудит ХХК
Захирал: Ш.Сувдаа
Утас: 99996778, 99059081
Цахим хаяг: smaudit97@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Албан шаардлага	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
ПГУ	Полимеразын гинжин урвал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Улаас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.08.25 № 07/379
танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА
Д.НАРАНТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	630,595,380.98	1,419,431,027.96
33	АВЛАГА	182,000,090.08	484,856,403.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,388,043.84
335	Бусад авлага	182,000,090.08	483,468,359.39
3351	Байгууллагаас авах авлага	182,000,090.08	483,468,359.39
34	УРЬДЧИЛГАА	393,079,926.81	-
3471	Урьдчилгаа тооцоо	393,079,926.81	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	259,868,987.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	58,786,199.81	-
34714	Томилолтын урьдчилгаа	74,424,740.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	55,515,364.09	934,574,624.73
351	Түүхий эд материал	28,617,173.33	868,276,078.97
35110	Тусгай зориулалттай материал	28,617,173.33	38,979,313.33
35130	Эм боох материал	-	829,296,765.64
354	Хангамжийн материал	26,898,190.76	66,298,545.76
35410	Бичиг хэргийн материал	10,887,264.66	6,282,731.66
35420	Аж ахуйн материал	2,140,450.90	4,959,160.90
35430	Сэлбэг хэрэгсэл	3,940,542.00	5,730,300.00
35440	Түлш, шатах тослох материал	-	8,293,950.00
35450	Барилгын засварын материал	-	19,250,600.00
35470	Бусад хангамжийн материал	9,929,933.20	21,781,803.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,194,231,168.08	2,565,209,361.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,194,231,168.08	2,565,209,361.25
392	Биет хөрөнгө	880,393,846.48	2,251,372,039.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	410,605,737.00	410,605,737.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,830,051.04)	(89,895,076.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,588,079,315.31	3,103,079,173.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,088,565,854.31)	(1,260,313,245.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,735,419.00	107,010,249.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,095,930.53)	(43,255,331.38)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,925,475.00	18,925,475.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,516,699.92)	(11,275,049.88)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	10,446,825.00	10,446,825.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(9,590,056.24)	(10,156,384.36)
39217	Ном	16,199,667.21	16,199,667.21
393	Биет бус хөрөнгө	313,837,321.60	313,837,321.60
39301	Програм хангамж	2,473,000.00	2,473,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,473,000.00)	(2,473,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	313,837,321.60	313,837,321.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,824,826,549.06	3,984,640,389.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,332,917.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,332,917.00
413	Өглөг	-	1,332,917.00
4136	Бусад өглөг	-	1,332,917.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,332,917.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,824,826,549.06	3,983,307,472.21
51	Засгийн газрын хувь оролцоо	1,824,826,549.06	3,983,307,472.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,715,526,272.67	2,715,526,272.67
51101	Өмч: - төрийн	2,715,526,272.67	2,715,526,272.67
512	Хуримтлагдсан үр дүн	(1,320,932,714.83)	837,548,208.32
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,320,932,714.83)	(1,320,932,714.83)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,158,480,923.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,232,991.22	430,232,991.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,824,826,549.06	3,984,640,389.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,524,664,997.75	8,905,024,491.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,525,764.00	2,516,986,817.02
120	Нийтлэг татварын бус орлого	95,525,764.00	2,516,986,817.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,525,764.00	2,516,986,817.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	90,012,501.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	95,525,764.00	2,426,974,316.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,429,139,233.75	6,388,037,674.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,464,743,700.00	3,240,908,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,464,743,700.00	3,240,908,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,964,395,533.75	3,147,129,174.53
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	650,211,656.00	1,021,038,680.18
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,591,760,221.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,314,183,877.75	534,330,273.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,511,687,600.62	6,746,543,568.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,511,687,600.62	6,746,543,568.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,496,847,809.67	6,277,396,448.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,611,793,731.50	2,760,488,351.42
210101	Үндсэн цалин	741,003,990.50	2,297,906,561.79
210102	Нэмэгдэл	870,789,741.00	197,616,239.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	118,059,023.20
210104	Урамшуулал	-	146,906,527.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,138,934.47	362,512,839.50
210201	Тэтгэврийн даатгал	155,032,741.43	263,919,480.19
210202	Тэтгэмжийн даатгал	12,220,681.21	25,780,193.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,776,544.37	19,938,714.43
210204	Ажилгүйдлийн даатгал	2,282,633.95	4,409,330.34
210205	Эрүүл мэндийн даатгал	22,826,333.51	48,465,121.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,413,100.00	76,982,402.76
210301	Гэрэл, цахилгаан	33,642,393.00	42,690,341.11
210302	Түлш, халаалт	24,542,655.70	26,256,459.65
210303	Цэвэр, бохир ус	6,228,051.30	8,035,602.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,593,490.34	405,796,960.18
210401	Бичиг хэрэг	6,968,802.60	35,684,449.00
210402	Тээвэр, шатахуун	23,976,308.34	38,339,082.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,459,642.70	31,653,140.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,270,000.00	7,055,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	598,600.00	293,065,288.00
210408	Бараа материал акталсны зардал	101,320,136.70	-
2105	Нормативт зардал	790,500.00	855,539,010.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	790,500.00	845,850,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,688,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,322,645.00	50,246,377.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,618,200.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	530,800.00
210604	Урсгал засвар	29,704,445.00	49,715,577.88
2107	Томилот, зочны зардал	7,760,000.00	111,903,400.00

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	7,760,000.00	111,903,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,995,255.00	803,088,271.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,804,195.00	796,464,759.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,100,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	57,252.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	1,021,260.00	2,311,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,425,040,153.36	850,838,835.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,160,250.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,300,160,679.46	598,382,089.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,879,473.90	213,296,495.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,839,790.95	469,147,120.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	253,673,372.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	105,333,372.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	148,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,039,790.95	215,473,747.62
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,523,915.20	160,470,981.86
213304	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	6,515,875.75	55,002,765.76
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,977,397.13	2,158,480,923.15
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,977,397.13	2,158,480,923.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,715,526,272.67	430,232,991.22	(1,333,910,111.96)	1,811,849,151.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,715,526,272.67	430,232,991.22	(1,333,910,111.96)	1,811,849,151.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	12,977,397.13	12,977,397.13
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,715,526,272.67	430,232,991.22	(1,320,932,714.83)	1,824,826,549.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,715,526,272.67	430,232,991.22	(1,320,932,714.83)	1,824,826,549.06
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,158,480,923.15	2,158,480,923.15
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,715,526,272.67	430,232,991.22	837,548,208.32	3,983,307,472.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,570,603,999.61	6,660,050,265.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	90,012,501.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	90,012,501.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	90,012,501.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,570,603,999.61	6,570,037,764.61
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,464,743,700.00	3,240,908,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,464,743,700.00	3,240,908,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,105,860,299.61	3,329,129,264.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	791,676,421.86	1,153,038,770.26
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,591,760,221.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,314,183,877.75	584,330,273.25
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,481,532,599.61	6,580,779,465.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,481,532,599.61	6,580,779,465.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,284,692,718.58	5,628,163,986.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,607,538,012.42	2,760,488,351.42
210101	Үндсэн цалин	1,382,470,551.09	2,297,542,774.31
210102	Нэмэгдэл	195,193,507.45	197,970,383.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,873,953.88	118,293,581.12
210104	Урамшуулал	-	146,681,612.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,813,631.06	363,900,883.34
210201	Тэтгэврийн даатгал	154,430,110.19	265,307,524.04
210202	Тэтгэмжийн даатгал	13,027,397.58	25,780,193.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,310,835.68	19,938,714.43
210204	Ажилгүйдлийн даатгал	2,549,756.23	4,409,330.33
210205	Эрүүл мэндийн даатгал	25,495,531.38	48,465,121.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,413,100.00	76,549,985.76
210301	Гэрэл, цахилгаан	33,642,393.00	42,690,341.11
210302	Түлш, халаалт	24,542,655.70	24,923,542.65
210303	Цэвэр, бохир ус	6,228,051.30	8,936,102.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,762,353.64	170,196,840.18
210401	Бичиг хэрэг	6,968,802.60	46,625,215.00
210402	Тээвэр, шатахуун	23,976,308.34	45,996,032.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,459,642.70	31,653,140.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,270,000.00	7,055,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,600.00	38,867,452.00
2105	Нормативт зардал	790,500.00	963,185,620.00
210501	Эм, бэлдмэл, бодисыг хэрэгсэл	790,500.00	940,804,020.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	22,381,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,982,645.00	78,064,845.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,278,200.00	11,947,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	530,800.00
210604	Урсгал засвар	29,704,445.00	65,586,795.00
2107	Томиллолт, зочны зардал	7,760,000.00	111,903,400.00
210702	Дотоод албан томиллолт	7,760,000.00	111,903,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,501,255.00	452,746,860.24

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,310,195.00	446,123,348.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,100,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	57,252.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	1,021,260.00	2,311,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,312,131,221.46	651,127,200.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,650,250.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,312,131,221.46	611,476,949.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,839,881.03	952,615,479.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	253,673,372.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	105,333,372.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	148,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	195,039,881.03	698,942,107.01
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,523,915.20	160,470,981.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	89,071,400.00	79,270,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	89,071,400.00	79,270,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,071,400.00	79,270,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	89,071,400.00	79,270,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	89,071,400.00	79,270,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(89,071,400.00)	(79,270,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,440,908,500.00	3,170,450,019.14	270,458,480.86	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,440,908,500.00	3,170,450,019.14	270,458,480.86	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,332,635,100.00	3,062,176,646.58	270,458,480.86	91.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,112,545,800.00	1,904,334,899.22	208,210,900.78	90.1
210101	Үндсэн цалин	1,319,248,000.00	1,441,389,322.11	(122,141,322.11)	109.3
210102	Нэмэгдэл	438,110,800.00	197,970,383.16	240,140,416.84	45.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	157,300,000.00	118,293,581.12	39,006,418.88	75.2
210104	Урамшуулал	197,887,000.00	146,681,612.83	51,205,387.17	74.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,193,800.00	253,734,634.27	31,459,165.73	89
210201	Тэтгэврийн даатгал	200,691,900.00	178,068,517.03	22,623,382.97	88.7
210202	Тэтгэмжийн даатгал	21,125,500.00	19,907,424.40	1,218,075.6	94.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,900,400.00	15,240,499.72	1,659,900.28	90.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,225,100.00	3,681,290.05	543,809.95	87.1
210205	Эрүүл мэндийн даатгал	42,250,900.00	36,836,903.07	5,413,996.93	87.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,550,000.00	76,549,985.76	14.24	100
210301	Гэрэл, цахилгаан	42,965,500.00	42,690,341.11	275,158.89	99.4
210302	Түлш, халаалт	24,626,000.00	24,923,542.65	(279,542.65)	101.2
210303	Цэвэр, бохир ус	8,958,500.00	8,936,102.00	22,398.00	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	84,349,300.00	84,269,384.18	79,915.82	99.9
210401	Бичиг хэрэг	29,023,500.00	29,032,755.00	(9,255.00)	100
210402	Тээвэр, шатахуун	8,445,000.00	8,444,910.24	89.76	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,710,600.00	10,120,016.94	(409,416.94)	104.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,525,000.00	7,055,000.00	470,000.00	93.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,645,200.00	29,616,702.00	28,498.00	99.9
2105	Нормативт зардал	465,490,500.00	454,546,170.00	10,944,330.00	97.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	443,108,900.00	432,164,570.00	10,944,330.00	97.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,381,600.00	22,381,600.00	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,589,600.00	87,060,386.00	16,529,214.00	84
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,913,600.00	27,446,650.00	16,466,950.00	62.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	530,800.00	530,800.00	-	100
210604	Урсгал засвар	59,145,200.00	59,082,936.00	62,264.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	8,000,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,246,300.00	154,030,937.00	3,215,363.00	98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,596,000.00	147,407,425.00	3,188,575.00	97.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,000.00	57,252.00	14,748.00	79.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00	11,000.00	83.3
210807	Газрын төлбөр	2,312,300.00	2,311,260.00	1,040.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,669,800.00	39,650,250.15	19,549.85	100

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,669,800.00	39,650,250.15	19,549.85	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,273,400.00	108,273,372.56	27.44	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	108,273,400.00	108,273,372.56	27.44	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,333,400.00	105,333,372.56	27.44	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,940,000.00	2,940,000.00	-	100
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		160,470,981.86	(160,470,981.86)	
	Төсөвт төвлөрүүлэх		160,470,981.86	(160,470,981.86)	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,440,908,500.00	3,170,450,019.14	270,458,480.86	92.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,240,908,500.00	3,080,437,518.14	160,470,981.86	95
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,240,908,500.00	3,080,437,518.14	160,470,981.86	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000,000.00	90,012,501.00	109,987,499.00	45
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000,000.00	90,012,501.00	109,987,499.00	45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110	110		
620001	Удирдах ажилтан	2	2		
620002	Гүйцэтгэх ажилтан	83	83		
620003	Үйлчлэх ажилтан	25	25		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,329,129,264.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,329,129,264.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,645,258,139.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		856,153,452.20
210101	Үндсэн цалин		856,153,452.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		110,166,249.07
210201	Тэтгэврийн даатгал		87,239,007.01
210202	Тэтгэмжийн даатгал		5,872,768.84
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,698,214.71
210204	Ажилгүйдлийн даатгал		728,040.28
210205	Эрүүл мэндийн даатгал		11,628,218.23
2104	Хангамж, бараа материалын зардал		89,294,956.00
210401	Бичиг хэрэг		17,592,460.00
210402	Тээвэр, шатахуун		37,551,122.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		21,533,124.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		12,618,250.00
2105	Нормативт зардал		520,283,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		520,283,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		38,830,059.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		32,326,200.00
210604	Урсгал засвар		6,503,859.00
2107	Томилолт, зочны зардал		103,903,400.00
210702	Дотоод албан томилолт		103,903,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		315,149,523.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		315,149,523.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		611,476,949.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		611,476,949.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		683,871,125.15
2132	Бусад урсгал шилжүүлэг		145,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		145,400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		538,471,125.15
213301	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		538,471,125.15
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,329,129,264.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,329,129,264.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,153,038,770.26
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,591,760,221.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		584,330,273.25

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, НББ-ийн хуулийг хэрэгжүүлэн ажиллах, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Эм Аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Эрдэнэчимэг, аудиторын туслах Д.Мягмаржаргал нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Чулуунбаатар, захирал Ш.Сувдаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлийг үндэсний түвшинд хэрэгжүүлэн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох
- Хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, зан үйл, орчны зүйлсийг тогтоох, үнэлэх, чиглэлээр судалгаа хийх, тандах, хянах судалгааны үр дүнг нийтэд болон холбогдох байгууллагуудад мэдээлэх, ухуулан сурталчлах, практикт нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, зонхилон тохиолдох өвчний эрт илрүүлгийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах мэдээлэх, хянах, үүнд салбарын байгууллагуудын оролцоог хангах, лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх
- Бусад салбарын бодлого, үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах ажил зохион байгуулах, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, лавлагаа зөвлөмжөөр хангах
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв дэх нийгмийн эрүүл мэндийн нэгж, халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр ажилладаг мэргэжлийн төвүүдэд мэргэжил арга зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх

- Биотехнологийн вакцин, биобэлдмэлийг турших, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,511,687.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 45,116.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 31,581.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,159,813.9 мянган төгрөгөөр буюу 118 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	182,000.1	484,856.4	302,856.3
Урьдчилгаа	393,079.9	-	(393,079.9)
Бараа материал	55,515.4	934,574.6	879,059.2
Үндсэн хөрөнгө	1,194,231.1	2,565,209.4	1,370,978.3
Нийт хөрөнгө	1,824,826.5	3,984,640.4	2,159,813.9
Өр төлбөр	-	1,332.9	1,332.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,824,826.5	3,983,307.5	2,158,481.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,824,826.5	3,984,640.4	2,159,813.9

- Авлагын дансны 484,856.4 мянган төгрөгийн үлдэгдэл нь Олон улсын байгууллагын төслийн санхүүжилтийн үлдэгдэл 431,847.6 мянган төгрөг, Эрүүл мэндийг дэмжих сангийн үлдэгдэл 53,008.8 мянган төгрөгийн санхүүжилтийг төрийн санд төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 879,059.3 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь тайлант онд Биобэлдмэлийн үйлдвэр ашиглалтад орж үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой 53,533.2 мянган төгрөгийн худалдан авалт, Ковид 19 илрүүлэх ПГУ лабораторийн оношлуурын урвалж бодис авахад 719,206.2 мянган төгрөг, ЭМЯ, ХӨСҮТ-өөс хуваарилсан 908,952.4 мянган төгрөг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар болон ЭМС-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 9 дүгээр албан даалгаврын дагуу Коронавируст халдвар (Ковид 19)-ын цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах 2-3 сарын нөөц бүрдүүлэн 234,790.3 мянган төгрөг, нийт 1,916,482.1 мянган төгрөгийн бараа материал орлогод авч, 1,037,422.8 мянган төгрөгийн материал зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,370,978.2 мянган төгрөгөөр өссөн нь ПГУ-ын шинжилгээ хийх, Молекул биологийн лабораторид ашиглахаар улсын төсвийн хөрөнгөөр 79,070.8 мянган төгрөгийн худалдан авалт, 1,466,549.2 мянган төгрөгийн хандив, Хаан банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар 38,654.7 мянган төгрөг, нийт 1,584,274.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэснээс шалтгаалжээ.
- УБДС ТӨҮГ-аас 12 дугаар сарын дулааны төлбөрийн бичилт хийгдсэн бөгөөд уг төлбөр төлөгдөөгүйгээс тайлант онд 1,332.9 мянган төгрөгөөр өр төлбөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 3,240,908.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 200,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл

ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 3,440,908.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,240,908.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 90,012.5 мянган төгрөг, нийт 3,330.921.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,170,450.0 мянган төгрөгийг зарцуулж, 160,471.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг 3,170,450.0 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байна. Үүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ холбоотой зардлаас 239,670.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 79.9 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслээс 10,944.3 мянган төгрөг, эд хогшил урсгал завсрын зардлаас 16,529.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж, бусад зардлаас 3,235.0 мянган төгрөг, нийт 270,458.5 мянган төгрөг буюу 7.9 хувь хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 1,153,038.8 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан мөнгө 1,591,760.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 584,330.3 мянган төгрөг, нийт 3,329,129.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 966,319.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 89,295.0 мянган төгрөг, норматив зардалд 520,283.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 38,830.1 мянган төгрөг, томилолт зочны зардал 103,903.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр 315,149.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 611,476.9 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 145,400.0 мянган төгрөг, нийт 2,790,658.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 538,471.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2021 оны төлөвлөгөөний хүрээнд иргэд, байгууллага, салбар дундын оролцоонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, мэргэжил, арга зүйгээр хангах, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд 2021 онд 4 зорилтыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

1. Үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог сайжруулж, хүний нөөцийн хөгжлийг хангах зорилтын хүрээнд 7 арга хэмжээ,
2. Өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд 14 арга хэмжээ,
3. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлийн тандалт, судалгааг өргөжүүлэн нотолгоонд тулгуурласан арга зүйг хөгжүүлэх зорилтын хүрээнд 11 арга хэмжээ,
4. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангаж ажиллах зорилтын хүрээнд 8 арга хэмжээг, эдгээр зорилтын хүрээнд нийт 382 үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 144 дүгээр тогтоолоор “Цар тахлын эсрэг биобэлдмэлийн бүтэгдэхүүн үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай” Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв Биобэлдмэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ПГУ-ын шинжилгээний молекул биологийн лаборатори гэсэн 2 чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 онд тус үйлдвэр 5,864 бортого хүний хэвийн иммуноглобулиныг үйлдвэрлэсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд 1003 хүнээс 82,627.2 мянган төгрөг, лавлагаа лабораторид 7,385.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн. Ковидын 1 удаагийн оношлуур шинжилгээг 82,370-82,500 төгрөгөөр авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 22 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 7,231,965.9 мянган төгрөгийн 167 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 177,976.4 мянган төгрөгийн 7 мэдээллийг ил тод байршуулаагүй, 4,490,047.7 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.
АХГ-2022/64/НА-СТА-ТШЗ

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн тайлангийн завсрын аудит хийх хугацаанд Сангийн яамны шалгалт давхардсан шалтгаанаар хийгдээгүй байна. Тухайн аудитаар ЗГ-ийн 2021 оны 144 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас олгосон хөрөнгө, Биобэлдмэлийн үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх, жигдрүүлэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын багцад багтаан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулсан хөрөнгө, төвийн 2021 оны төсөвт Биобэлдмэлийн үйлдвэрийн урсгал зардалд зарцуулсан хөрөнгийн зарцуулалтад шалгалт хийжээ. Шалгалтаар дараах 2 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн яамны Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, Биобэлдмэлийн үйлдвэрт хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажилд холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан үүсээд байгаа нөхцөл байдлыг яаралтай шийдвэрлэн Засгийн газрын 144 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар шуурхай ажиллах,
2. Мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Биобэлдмэлийн үйлдвэрийг сэргээх, үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхээр улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн ашиглалтыг хангуулах шаардлага тавьжээ.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 19,453.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	19,453.0	1	19,453.0			100
Нийт дүн	1	19,453.0	1	19,453.0			100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог сайжруулах, талаар сургалт явуулж байгаа төслүүдийн хэрэгжилтийг анхаарах мөн Биобэлдмэлийн үйлдвэрийн хөрөнгийн бүртгэл, зарцуулалтын талаар дараагийн аудитаар авч үзэх болно.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 224,226.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 191,741.8 мянган төгрөгийн 1 зөрчлийг залруулж, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нийт 14 байгууллагаас худалдан авсан 191,741.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасныг залруулан баталгаажуулсан.

4.2 Албан шаардлага

Европын Q32 төсөл, Хаан банкнаас өгсөн 13,018.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авч бүртгэхдээ хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, ХӨСҮТ-өөс хуваарилсан 19,466.5 мянган төгрөгийн бараа материалыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нийт 32,484.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 4.

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
						Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	АХГ-2022/64/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд 14 байгууллагаас худалдан авсан 191,741.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хоорондын тооцоогоор дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан байна.	1	191,741.8	1	191,741.8				
2	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	АХГ-2022/64/Н А-СТА-ТШЗ	Европын Q32 төсөл, Хаан банкнаас өгсөн 13,018.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авч бүртгэхдээ акт үйлдээгүй, ХӨСҮТ-өөс хуваарилсан 19,466.5 мянган төгрөгийн бараа материалыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нийт 32,484.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.	1				1	-		
3	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	АХГ-2022/64/Н А-СТА-ТШЗ	2021 онд нийт 167 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 177,976.4 мянган төгрөгийн 7 мэдээллийг ил тод байршуулаагүй, 4,490,047.7 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	1						1	-
	Нийт			3	191,741.8	1	191,741.8	1	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 296/Н0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/64/НБ-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Европын Q32 төсөл, Хаан банкнаас өгсөн хандивыг хүлээн авсан актгүй, Халдвэрт өвчин судлалын үндэсний төвөөс хуваарилсан бараа материалыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хандиваар болон ХӨСҮТ-өөс хуваарилсан бараа материалыг тооцоо нийлж, актаар тулган баталгаажуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Д.Нарантуяа, нягтлан бодогч А.Болор-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЭМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ш.СУВДАА

001080668

